



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 10 өдөр

Дугаар А/10

Чингис хот

Устгалын ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5, 19 дүгээр зүйлийн 19.2.5, 19.3 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32.1.3, 32.1.4 дахь заалт, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2018 оны А/52 дугаар тоот тушаалын "Мал амьтны сэг зэм устгах үйл ажиллагааны заавар"-ын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторийн 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 25-622 тоот шинжилгээний дүнгээр Сариг багт гахайн африкийн мялзан өвчин оношлогдсон тул устгалын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй зохион байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Д.Буянбат -Байгаль орчны хяналтын улсын байцаагч
Нарийн бичгийн дарга:	Э.Мөнхбат Өндөрхаан тохижилт ОНӨААТҮ газрын дарга
Гишүүд:	Л.Ганбаатар- Засаг даргын Тамгын газрын нярав
	Э.Машбаяр- Засаг даргын Тамгын газрын жижүүр
	Г.Золбаяр- Засаг даргын Тамгын газрын жижүүр
	Н.Нууц-Эрдэнэ- Засаг даргын Тамгын газрын жижүүр
	Ц.Энхмандах- Өндөрхаан тохижилт ОНӨААТҮ газрын жолооч
	Э.Батзориг-Өндөрхаан тохижилт ОНӨААТҮ газрын жолооч
	Г.Олдох-Өндөрхаан тохижилт ОНӨААТҮ газрын цахилгаанчин
	Р.Шүрэнцэцэг-Их түмт МЭҮН-ийн малын эмч

2. Өвчтэй гахайг устгаж, орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн ажлыг зохих заавар журмын дагуу чанартай хийж гүйцэтгэхийг ажлын хэсгийн ахлагч (Д.Буянбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



А.БОРГИЛ